



ИНД - 175

Иргэний Нисэхийн Дүрэм

**Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын
гэрчилгээжүүлэлт**

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- ИНЕГ-ын өмнөөс Монгол Улсад Нисэхийн Мэдээллийн Үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны;
- Монгол Улсын Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (цаашид AIP гэх), Нисэхийн мэдээллийн цуврал (цаашид AIC гэх) болон NOTAM.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-175-ын цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-175, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн дугаар**Хүчин төгөлдөр болсон огноо**

Анхны боловсруулалт

2003 оны 06 сарын 05

Нэмэлт, өөрчлөлт 1

2007 оны 09 сарын 18

Нэмэлт, өөрчлөлт 2

2010 оны 03 сарын 22

Нэмэлт, өөрчлөлт 3 (Шинэчлэлт)

2019 оны ... сарын ...

Тэмдэглэл: ИНД-175-ын шинэчлэлтийг монгол, англи хэл дээр, NZ Part 175-ын 2017 оны 03 сарын 10-ны А.8-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

А Бүлэг - Ерөнхий	1
175.1. Хамрах хүрээ	1
175.3. Гэрчилгээний шаардлага	1
175.5. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах.....	1
175.7. Гэрчилгээ олгох	1
175.9. Гэрчилгээ эзэмшигчийн эрх.....	1
175.11. Гэрчилгээний хугацаа	1
175.13. Гэрчилгээ сунгах.....	2
В Бүлэг – Гэрчилгээжүүлэлтийн шаардлага	3
175.51. Ажилтанд тавих шаардлага.....	3
175.53. Байгууламжийн шаардлага	3
175.55. Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний хамрах хүрээ	4
175.57. Баримт бичиг	4
175.59. Мэдээлэл цуглуулах.....	4
175.61. Нисэхийн мэдээллийг хэвлэн нийтлэх.....	5
175.63. Хэвлэн нийтэлсэн мэдээллийн алдааг залруулах	7
175.65. Бүртгэл.....	7
175.67. Аюулгүй байдлын удирдлага.....	8
175.69. НМҮ-ний байгууллагын Ерөнхий заавар.....	8
С Бүлэг - Үйл ажиллагааны шаардлага	9
175.101. Байнгын хэрэгжилт	9
175.103. АIP-ын үйлчилгээ.....	9
175.105. NOTAM-ын үйлчилгээ	10
175.107. Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ	10
175.109. Гэрчилгээ эзэмшигч байгууллагын өөрчлөлт	11
Д Бүлэг - Монгол Улсын АIP	13
175.151. Монгол Улсын АIP-ын агуулга	13
175.153. Монгол Улсын АIP-ын тодорхойлолт	14
175.155. АIP-ын Нэмэлт өөрчлөлтийн тодорхойлолт	14
175.157. АIP-ын Нэмэлтэд хавсралтын тодорхойлолт	15
Е Бүлэг - АIC	15
175.201. АIC-ын тодорхойлолт	15
F Бүлэг - NOTAM	16
175.251. NOTAM-ын тодорхойлолт	16
Г Бүлэг - Шилжилтийн зохицуулалт	17
175.301. НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн шилжилт	17
175.303. НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн шилжилтийн дотоод чанар баталгаажуулалт	18

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт

А Бүлэг - Ерөнхий

175.1. Хамрах хүрээ

Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) Монгол Улсад Нисэхийн Мэдээллийн Үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны;
- (2) Монгол Улсын AIP, AIC болон NOTAM.

175.3. Гэрчилгээний шаардлага

Энэ Дүрмийн дагуу олгосон нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын (цаашид НМҮ-ний байгууллага гэх) гэрчилгээний эрх болон нөхцөлд зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд НМҮ-г Монгол Улсын FIR-д үзүүлэхгүй.

175.5. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах

НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь САА 24175/01 маягыг бөглөж, дараах баримтын хамт Даргад хүргүүлнэ:

- (1) 175.69-д шаардсан Ерөнхий заавар;
- (2) зохих хүсэлтийн хураамжийн төлбөр.

175.7. Гэрчилгээ олгох

Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, хүсэлт гаргагч нь НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмших эрхтэй

- (1) хүсэлт гаргагч нь В Бүлгийн шаардлага хангасан байх;
- (2) хүсэлт гаргагч болон 175.51(a)(1) болон (2)-т шаардсан хүсэлт гаргагчийн удирдах ажилтан, эсхүл ажилтнууд нь тохирох зөв хүн байх;
- (3) гэрчилгээ олгосноор нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.

175.9. Гэрчилгээ эзэмшигчийн эрх

НМҮ-ний байгууллагын гэрчилгээнд, тухайн гэрчилгээ эзэмшигчид зөвшөөрсөн НМҮ-г заана.

175.11. Гэрчилгээний хугацаа

- (a) НМҮ-ний байгууллагын гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно.
- (b) НМҮ-ний байгууллагын гэрчилгээ нь түүний хугацаа дууссан, түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд хүчинтэй хэвээр байна.

(c) НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хугацаа дууссан, эсхүл хүчингүй болсон бол Даргад нэн даруй хураалгана.

(d) Гэрчилгээг түдгэлзүүлсэн бол НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь зохих баталгаажуулсан бичилт хийлгэхээр гэрчилгээг Даргад нэн даруй хүргүүлнэ.

175.13. Гэрчилгээ сунгах

(a) НМҮ-ний байгууллагын гэрчилгээ сунгуулах хүсэлтийг САА 24175/01 маягтын дагуу гаргана.

(b) Сунгуулах хүсэлтийг гэрчилгээнд заасан хугацаанаас өмнө, эсхүл хэрэв сунгах хугацааг заагаагүй бол гэрчилгээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө Даргад хүргүүлнэ.

В Бүлэг – Гэрчилгээжүүлэлтийн шаардлага

175.51. Ажилтанд тавих шаардлага

(a) НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтныг үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр ажиллуулах үүрэгтэй:

- (1) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан НМҮ бүрийг дараах хэлбэрээр тухайн байгууллагын хүрээнд бататгах эрхтэй Гүйцэтгэх захирлаар тодорхойлогдсон удирдах ажилтан:
 - (i) үйл ажиллагааны шаардлагад нийцүүлэн, санхүүжүүлж чадахаа;
 - (ii) энэ Дүрэмд заасан шаардлагыг хангаж ажиллахаа;
- (2) Гүйцэтгэх захирлын өмнө дараах эцсийн хариуцлага хүлээх удирдах ажилтан, эсхүл ажилтнууд:
 - (i) тухайн байгууллага нь Ерөнхий заавартаа нийцэж байгааг бататгах;
 - (ii) 175.67-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо;
- (3) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт заасан НМҮ-нд зориулсан нисэхийн мэдээллийг цуглуулах, эмхлэх, шалгах, зохицуулах, боловсруулах болон хэвлэх хангалттай тооны ажилтан.

(aa) Энэ зүйлийн (a)(2)(ii)-т шаардсан удирдах ажилтан нь тухайн гэрчилгээ эзэмшигчийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болон үйл ажиллагаатай холбоотой ур чадвар болон туршлагаа харуулах чадвартай байх үүрэгтэй.

(b) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй

- (1) Ерөнхий зааварт заасан НМҮ-нд зориулсан нисэхийн мэдээллийг шалгах, боловсруулах болон хэвлэх зорилгоор хүсэлт гаргагчийн эрх олгосон ажилтны ур чадварын анхны үнэлгээг хийх журмыг тогтоох;
- (2) эрх бүхий ажилтны ур чадварыг хадгалах журмыг тогтоох;
- (3) эрх бүхий ажилтанд, түүний зөвшөөрлийн хүрээг тодорхойлсон нотлох баримтыг бичгээр олгох.

175.53. Байгууламжийн шаардлага

НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажлын байр болон байгууламжтай байна:

- (1) Ерөнхий зааварт заасан НМҮ-нд тохирсон;
- (2) 175.103(b) болон 175.105-ын холбогдох шаардлагыг хангасан.

175.55. Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний хамрах хүрээ

Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий заавартаа заасан нислэгийн өмнөх үйлчилгээнд зориулж дараах бүс, замыг заана:

- (1) газар зүйн бүс;
- (2) аэродром болон тухайн аэродромоос эхлэх агаарын зам.

175.57. Баримт бичиг

(a) НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд хэвлэн нийтэлдэг нисэхийн мэдээллийн формат болон стандартыг тогтоох;
- (2) тухайн формат болон стандарт нь мэдээллийг ашиглах нөхцөл байдлыг тооцон үздэг болохыг бататгах;
- (3) Ерөнхий зааварт заасан НМҮ-нд шаардлагатай лавлагааны материал, стандарт, журам болон бусад холбогдох баримт бичгийн хувийг хадгалдаг байх.

(b) Хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах зорилгоор энэ зүйлийн (a)-д шаардсан бүх баримт бичгийг хянах журмыг тогтооно:

- (1) тухайн баримт бичгийг гаргахын өмнө холбогдох ажилтан хянаж, зөвшөөрдөг байх;
- (2) баримт бичгийн хүчинтэй хувь нь, ажилтан Ерөнхий зааварт заасан НМҮ-нд зориулсан баримт бичгийг ашиглахад хэрэгтэй байрлал бүрд бэлэн байх;
- (3) хугацаа нь дууссан баримт бичгийг олгох, эсхүл ашиглах бүх цэгээс нэн даруй хурааж авдаг байх;
- (4) баримт бичигт орсон өөрчлөлтийг холбогдох ажилтан хянаж, бататгадаг байх;
- (5) баримт бичгийн хүчинтэй хувилбар нь хүчингүй болсон хэвлэлтийг ашиглахаас сэргийлж танигддаг байх.

175.59. Мэдээлэл цуглуулах

(a) НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий зааварт заасан НМҮ-нд шаардлагатай мэдээллийг цуглуулах болон эмхлэх журмыг тогтоосон байна.

(b) Тухайн журам нь дараах шаардлагыг бататгасан байна:

- (1) холбогдох мэдээллийг Монгол Улсын агаарын навигацийн системийг дэмжих үйлчилгээ үзүүлдэг байгууллагаас авдаг байх;
- (2) Монгол Улсаас эхэлж байгаа олон улсын агаарын замд нислэг үйлдэж байгаа, олон улсын агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн шаардлагад хамаарах холбогдох мэдээллийг бусад Улсын НМҮ-ний байгууллагаас авдаг байх;

- (3) цаг тухайд нь мэдээллээр хангах зохицуулалтыг энэ зүйлийн (b)(1) болон (2)-т заасан мэдээлэгч этгээдтэй хамтран хийдэг байх;
- (4) энэ зүйлийн (b)(1)-д заасан мэдээлэгч этгээдээс хүлээн авсан мэдээллийг тухайн мэдээллийн үнэн зөвийг хариуцсан эх сурвалжийн томилсон этгээд үнэн зөв болохыг баталгаажуулдаг байх.

(c) Энэ зүйлийн (b)-д зааснаас гадна, NOTAM үйлчилгээний журам нь NOTAM гаргах аливаа эх сурвалжийн хүсэлтийг тухайн NOTAM-ыг 3 сараас дээш хугацаагаар хүчинтэй байхыг шаарддаггүй болохыг бататгана.

175.61. Нисэхийн мэдээллийг хэвлэн нийтлэх

(a) НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий зааварт заасан үйлчилгээнд ашиглах нисэхийн мэдээллийг шалгах, зохицуулах, боловсруулах, хэвлэн нийтлэх ба түгээх журмыг тогтооно.

(b) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (a)-ийн дагуу тогтоосон журамд дараах шаардлагыг заасан болохыг бататгана:

- (1) 175.59-д заасны дагуу хүлээн авсан мэдээллийг хэвлэн нийтлэхийн өмнө боломжит мэдээлэл ашиглан түүний үнэн зөвийг бататган, шалгадаг байх;
- (2) 175.59-д заасны дагуу хүлээн авсан мэдээллийг дараах хэлбэрээр боловсруулдаг, үнэн зөв хэвлэн нийтэлдэг болон түгээдэг байх:
 - (i) тухайн мэдээллийн үйл ажиллагааны ач холбогдолд тохирсон форматаар;
 - (ii) хамааралтай бол D, E, эсхүл F Бүлгийн дагуу;
 - (iii) тухайн мэдээллийг ашиглах нөхцөл байдлыг тооцон үзсэн форматаар.
- (3) энэ зүйлийн (b)(4)-т зааснаас бусад тохиолдолд, байнгын мэдээлэл болон урт хугацаатай, түр шинж чанартай мэдээллийг тухайн хүсэлт гаргагчийн НМҮ-ний байгууллагын гэрчилгээний эрхийн хүрээнд хэвлэн нийтэлсэн болох нь тодорхой танигддаг байх;
- (4) хэрэв 175.59(b)(2)-ын дагуу бусад Улсын НМҮ-ний байгууллагаас авсан нисэхийн мэдээллийг түгээх бол, уг мэдээллийг тухайн улсын эрх бүхий байгууллагаас хүлээн авсан болохыг тодорхой таньж тогтоодог байх;
- (5) хэрэв 175.59(b)(4)-т заасны дагуу үнэн зөвийг баталгаажуулаагүй мэдээллийг түгээх бол, тухайн мэдээллийг баталгаажуулаагүй болохыг тодорхой таньж тогтоодог байх;
- (6) хэвлэн нийтэлсэн мэдээлэлд тогтмол шинж чанартай өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн өөрчлөлтийг хэвлэн нийтлэхийн өмнө холбогдох бусад мэдээлэгч этгээдтэй хамтран зохицуулалт хийдэг байх;
- (7) тогтоосон, дуусах хугацаагүй хэвлэн нийтэлсэн түр мэдээллийг, мэдээлэгчээс тухайн мэдээллийг цуцлах, эсхүл дахин гаргахыг шаардсан арга хэмжээ авдаг болохыг бататгах зорилгоор тодорхой хугацаанд хянадаг байх;
- (8) нисэхийн мэдээллийг **англи хэл** дээр хэвлэн нийтэлдэг байх;

- (9) газрын орны нэрийг орон нутгийн хэллэгийн дагуу үсэглэн бичих шаардлагатай тохиолдолд латин үсгээр галиглаж бичих;
 - (10) хэмжлийн нэгж нь ИНД-91.4-т заасантай нийцсэн байх;
 - (11) хэвлэн нийтэлсэн нисэхийн мэдээлэлд ИНД-ийн тайлбарт заасан товчлолыг хэрэглэдэг байх, хэрэв:
 - (i) хэрэглээ нь тохирч байгаа бол;
 - (ii) хэрэглээ нь мэдээллийн түгээлтийг хялбаршуулж байгаа бол;
 - (12) бусад Улсын НМҮ-ний байгууллагаас хүсэлт гаргасан тохиолдолд хэвлэн нийтэлсэн аливаа нисэхийн мэдээллийг нэн даруй дамжуулдаг байх;
 - (13) нисэхийн мэдээллийг дараах хэрэглэгчийн үйл ажиллагааны шаардлагад тохирох хэлбэрээр ашиглахад бэлэн байлгах:
 - (i) нисэх багийн гишүүд болон нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээг багтаасан нислэгийн үйл ажиллагааны ажилтнууд;
 - (ii) НМҮ хариуцсан НХҮ-ний нэгж.
- (c) Хүсэлт гаргагч нь AIP-ын үйлчилгээний журамд энэ зүйлийн (b)-д зааснаас гадна дараах шаардлага багтсан болохыг бататгах үүрэгтэй:
- (1) нислэгийн зураг, AIP-ын Нэмэлт өөрчлөлт болон AIP-ын Нэмэлт хавсралтад хэвлэн нийтэлсэн үйл ажиллагааны чухал ач холбогдолтой мэдээллийг AIRAC тогтолцооны дагуу хэвлэн нийтэлдэг байх;
 - (2) AIRAC тогтолцооны дагуу хэвлэн нийтлэх мэдээлэл нь AIRAC товчлолыг тодорхой харуулдаг байх;
 - (3) AIRAC тогтолцооны дагуу хэвлэн нийтэлсэн мэдээллийг, тухайн мэдээлэл хүчинтэй болохоос 28-аас доошгүй хоногийн өмнө хэрэглэгч хүлээн авсан байхаар түгээдэг байх;
 - (4) AIRAC тогтолцооны дагуу хэвлэн нийтэлсэн мэдээллийг тухайн хүчинтэй өдрөөс хойш 28-аас доошгүй хоногт, мэдэгдсэн нөхцөл байдал нь түр зуурын шинж чанартай ба бүхий л цаг хугацааны турш нөлөөлөхгүй байхаас бусад тохиолдолд өөрчилдөггүй байх;
 - (5) хэрэв AIP-ын Нэмэлт хавсралтыг NOTAM солих зорилгоор хэвлэн нийтэлсэн бол, тухайн Нэмэлт хавсралт нь NOTAM-ын серийн дугаарын ишлэлийг багтаадаг байх;
 - (6) хэрэв AIP-ын Нэмэлт өөрчлөлт, эсхүл AIP-ын Нэмэлт хавсралтыг AIRAC тогтолцооны дагуу хэвлэн нийтэлсэн бол, гарах NOTAM нь үйл ажиллагааны чухал ач холбогдолтой агуулга, хүчинтэй болох өдөр болон нэмэлт өөрчлөлт, эсхүл нэмэлт хавсралт бүрийн ишлэл татсан дугаарын товч тайлбарыг өгдөг байх. NOTAM нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:
 - (i) тухайн нэмэлт өөрчлөлт, эсхүл нэмэлт хавсралттай нэг өдөр хүчинтэй болдог байх;
 - (ii) 14 хоногийн хугацаанд хүчинтэй хэвээр байх;
 - (7) хэрэв AIRAC-ын хугацаанд хэвлэн нийтлэх холбогдох мэдээлэл байхгүй бол, NIL гэсэн тэмдэглэгээтэй нийтэлдэг байх;

- (8) хэрэв AIP-ын Нэмэлт өөрчлөлт, эсхүл AIP-ын Нэмэлт хавсралтаар хэвлэн нийтлэх мэдээлэл нь тухайн Нэмэлт өөрчлөлт, эсхүл Нэмэлт хавсралт хүчинтэй болох өдрөөс өмнө хүчинтэй болох бол, NOTAM гаргадаг байх.

175.63. Хэвлэн нийтэлсэн мэдээллийн алдааг залруулах

(a) НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд хэвлэн нийтэлсэн нисэхийн мэдээлэлд илэрсэн аливаа алдааг бүртгэх, шинжлэн шалгах, залруулах болон илтгэх журмыг тогтооно.

(b) Тухайн журам нь дараах шаардлагыг бататгасан байна:

- (1) тухайн алдааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөнөөс хамаарч хамгийн тохиромжтой хэлбэрээр залруулдаг байх;
- (2) дахин хэвлэн нийтэлсэн мэдээлэлд залруулга нь тодорхой танигддаг байх;
- (3) алдааны эх сурвалжийг таньж тогтоодог байх ба боломжтой бүх тохиолдолд устгадаг байх;
- (4) түгээгдсэн мэдээллийн зөрчлийг ИНД-12-ын дагуу Даргад мэдэгддэг байх.

175.65. Бүртгэл

(a) НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий зааварт заасан НМҮ-нд шаардлагатай бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, арчлах болон устгах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

(b) Тухайн журам нь дараах шаардлагыг бататгасан байх ёстой:

- (1) хүлээн авсан болон түгээсэн бүх нисэхийн мэдээллийг дэс дугаар болон хугацаагаар нь хялбар таньж тогтоох боломжтой бүртгэлтэй байх, нэмэлт мэдээллийг ижил төстэй байдлаар бататгадаг байх ба шаардлагатай тохиолдолд таньж тогтоодог байх;
- (2) хүсэлт гаргагчийн, нисэхийн мэдээллийг шалгах, боловсруулах болон хэвлэн нийтлэх эрх олгосон ажилтан бүрийн бүртгэлтэй байх;
- (3) 175.63-т шаардсан журмын дагуу алдааг залруулсан тохиолдол бүрийн бүртгэлтэй байх;
- (4) [хүчингүй]
- (5) бүх бүртгэл нь гаргацтай бөгөөд байнгын, арилдаггүй байх;
- (6) NOTAM, AIP-ын Нэмэлт хавсралт болон AIC-ыг цуцалснаас хойш 30 хоног, бусад бүх бүртгэлийг 5 жилээс доошгүй хугацаагаар хадгалдаг байх.

175.67. Аюулгүй байдлын удирдлага

НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-100.3-ын дагуу аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон үйл ажиллагаандаа мөрдөх үүрэгтэй.

175.69. НМҮ-ний байгууллагын Ерөнхий заавар

(а) НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг багтаасан Ерөнхий зааврыг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

- (1) Ерөнхий заавар болон түүнд багтсан бусад журамд дараах шаардлагыг багтаасан болохыг бататган, хүсэлт гаргагчийн нэрийн өмнөөс Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл:
 - (i) тухайн байгууллагыг тодорхойлох ба энэ Дүрмийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр болон аргыг харуулах;
 - (ii) түүнийг байнга дагаж мөрдөх;
- (1A) 175.67-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хувьд:
 - (i) ИНД-100.3(b)-д шаардсан бүх баримт бичиг;
 - (ii) НМҮ-ний байгууллагын гэрчилгээ сунгуулахаар хүсэлт гаргаагүй хүсэлт гаргагчийн хувьд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхийг дүрслэн харуулсан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө;
- (2) 175.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын албан тушаал болон нэр;
- (3) 175.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын дараах үүрэг, хариуцлагыг:
 - (i) тухайн байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харьцах тэдний хариуцсан асуудал;
 - (ii) аюулгүй байдлын удирдлагын үүрэг хариуцлага;
- (4) 175.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;
- (5) энэ зүйлийн (а)(6)-д заасан НМҮ-г үзүүлэх ажилтнуудын бүтцийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (5A) байгууллагын хүрээнд аюулгүй байдлын хариуцлагын шугаман хамаарлыг тодорхойлсон мэдээлэл;
- (6) гэрчилгээний дагуу үзүүлэх НМҮ-ний жагсаалт;
- (7) нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний хувьд, 175.55-д шаардсан газарзүйн бүс, аэродром болон агаарын замын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (8) 157.103(b)(1) болон 175.105(1)-д шаардсан нэгжийн байршил болон хаягийн дэлгэрэнгүй мэдээлэл;
- (9) хэвлэн нийтэлсэн нисэхийн мэдээллийн хувьд, 175.57(a)(1)-д шаардсан хүсэлт гаргагчийн формат болон стандартын дэлгэрэнгүй мэдээлэл;
- (10) дараах шаардлагатай холбоотой хүсэлт гаргагчийн журмын дэлгэрэнгүй:
 - (i) ажилтны ур чадвар;

- (ii) баримт бичгийн хяналт;
- (iii) мэдээлэл цуглуулах;
- (iv) нисэхийн мэдээллийг хэвлэн нийтлэх;
- (v) хэвлэн нийтэлсэн мэдээллийн алдааг залруулах;
- (vi) бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, арчлах болон устгах;

(11) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээх журам.

(b) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь Дарга хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.

С Бүлэг - Үйл ажиллагааны шаардлага

175.101. Байнгын хэрэгжилт

НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) Ерөнхий зааварт заасан ажлын байрлал тус бүрд, тухайн зааврын нэгээс доошгүй хүчинтэй, бүрэн хувийг хадгалдаг байх;
- (2) Ерөнхий заавартаа заасан бүх журам, стандартыг дагаж мөрддөг байх;
- (3) Ерөнхий зааврын холбогдох бүлэг бүрийг шаардлагатай ажилтан ажил үүргээ гүйцэтгэхэд ашиглах боломжтой байлгах;
- (4) гэрчилгээжүүлэлттэй холбоотой В Бүлгийн шаардлага, стандартыг байнга хангадаг байх;
- (5) САА 24175/01 маягтад шаардсан үйлчилгээний хаяг, утасны дугаар, эсхүл факсын дугаар өөрчлөгдсөн бол тухайн өөрчлөлтийг 28 хоногийн дотор Даргад мэдэгддэг байх.

175.103. AIP-ын үйлчилгээ

(a) AIP-ын үйлчилгээ үзүүлдэг НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь дараах мэдээллийг хэвлэн нийтлэх үүрэгтэй:

- (1) D Бүлгийн дагуу Монгол Улсын AIP;
- (2) 175.155-ын дагуу AIP-ын Нэмэлт өөрчлөлт;
- (3) 175.157-гийн дагуу дараах мэдээллийг AIP-ын Нэмэлт хавсралтаар:
 - (i) 3 сар, эсхүл түүнээс урт хугацаатай түр өөрчлөлтийг;
 - (ii) их хэмжээний текст, эсхүл график багтаасан, 3 сараас бага хугацаатай мэдээллийг;
- (4) E Бүлгийн дагуу AIC;

(b) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (a)-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) бусад улсын НМҮ-ний байгууллагатай Монгол Улсыг төлөөлөн харилцаж NOTAM-аас бусад Нисэхийн мэдээллийн нэгдсэн багцыг харилцан солилцох нэгжийг томилох;

- (2) тухайн мэдээллээр хангахтай холбоотой гарч болох төлбөрийг хийсний дараа Монгол Улсын AIP, AIP-ын Нэмэлт өөрчлөлт, AIP-ын Нэмэлт хавсралт болон AIC-ыг аливаа этгээд ашиглах боломжтой байлгах;
- (3) 175.61(c)(3)-ын дагуу Монгол Улсын AIP, AIP-ын Нэмэлт өөрчлөлт, AIP-ын Нэмэлт хавсралт, нислэгийн зураг болон AIC-ыг түгээх тогтолцоог бүрдүүлэх;
- (4) Монгол Улсын AIP-ын хэсгээр хэвлэн нийтлэгдсэн нислэгийн зураг бүрийг нислэгийн зургийн холбогдох стандартад нийцэж байгааг бататгах;
- (5) дараахаас бусад тохиолдолд, 175.59(b)(1)-д заасан эх сурвалжаас ирсэн бүх нисэхийн мэдээлэлд зохицуулалт хийх:
 - (i) NOTAM гаргахыг яаралтай шаардсан, үйл ажиллагааны хойшлуулшгүй чухал ач холбогдолтой мэдээлэл;
 - (ii) зөвхөн NOTAM гаргахыг шаарддаг, 3 сараас бага хугацаатай түр мэдээлэл.

175.105. NOTAM-ын үйлчилгээ

NOTAM-ын үйлчилгээ үзүүлдэг НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) Монгол Улсын олон улсын NOTAM-ын нэгжийг томилох;
- (2) олон улсын NOTAM-ын нэгжийг 24 цагаар ажиллуулах;
- (3) NOTAM солилцох зорилгоор, бусад олон улсын NOTAM-ын нэгжтэй гэрээ байгуулах;
- (4) дараах шаардлагыг бататгах:
 - (i) олон улсын NOTAM-ын нэгж нь AFTN-нд холбогдсон байх;
 - (ii) AFTN-ын холболт нь **хэвлэлийн өгөгдөл дамжуулах** (printed communication) чадвартай байх;
 - (iii) олон улсын NOTAM-ын нэгж нь цахилгаан холбоогоор түгээгддэг NOTAM хүлээн авах болон гаргах чадвартай байгууламжтай байх;
- (5) 175.59-ийн дагуу хүлээн авсан мэдээллийг NOTAM гаргах шаардлагатай тохиолдолд, F Бүлгийн дагуу түргэн шуурхай NOTAM гаргана;
- (6) AFTN-ээр дамжуулан, хүчинтэй байгаа NOTAM-ын шалгах хуудсыг 1 сараас ихгүй давтамжтай байхаар гаргана.

175.107. Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ

(а) Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үйл ажиллагааны ажилтан болон нисэх багийн гишүүнийг дараах нисэхийн мэдээллийг авч хэрэглэх боломжоор хангах үүрэгтэй:

- (1) агаарын навигацийн аюулгүй байдал, тогтмолжилт болон үр дүнд зайлшгүй шаардлагатай;
- (2) гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан газарзүйн бүс, аэродром болон агаарын замтай холбоотой.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу хангадаг нисэхийн мэдээлэл нь хамааралтай бол дараах мэдээллийг багтаасан байх ёстой:

- (1) хүчинтэй NOTAM-ын дэлгэрэнгүй болон яаралтай бусад мэдээллийг Нислэгийн өмнөх мэдээллийн бюллетений текст хэлбэрээр;
- (2) нисэхийн мэдээллийн нэгдсэн багцын холбогдох элемент;
- (3) холбогдох газрын болон нислэгийн зураг;
- (4) дараах хүчин зүйлийн талаарх нисэн гарах аэродромд хамааралтай хүчинтэй мэдээлэл:
 - (i) маневрын талбайд, эсхүл түүний ойролцоо барилгын, эсхүл засварын ажил;
 - (ii) ХБЗ болон явгалах замын гадаргуугийн эвдэрсэн хэсгийг багтаасан тэмдэглэгээтэй, эсхүл тэмдэглэгээгүй маневрын талбайн тэгш бус хэсэг;
 - (iii) гадаргуугийн барьцалтын нөлөөг багтаасан, ХБЗ болон явгалах зам дээр цас, мөс, эсхүл устай байх ба тэдгээрийн зузаан;
 - (iv) ХБЗ, эсхүл явгалах зам дээр, эсхүл түүний хажууд хунгарласан, эсхүл овоолсон цас;
 - (v) явгалах зам дээр, эсхүл түүний хажууд байгаа агаарын хөлөг, эсхүл бусад объект;
 - (vi) шувууг багтаасан бусад түр зуурын аюултай нөхцөл байх;
 - (vii) ойртолт, босго, ХБЗ, явгалах зам болон саадын болон маневрын талбайн ажиллагаагүй хэсгийн гэрэл болон аэродромын цахилгаан тэжээлийг багтаасан аэродромын гэрэлтүүлгийн системийн хэсэгчилсэн, эсхүл бүрэн ажиллагаагүй байдал, эсхүл хэвийн бус ажиллагаа;
 - (viii) ILS болон маркер, PSR, SSR, VOR, NDB, VHF аэромобил суваг, RVR ажиглалтын систем болон нөөц цахилгаан хангамжийг багтаасан агаарын навигацийн байгууламжийн үйл ажиллагааны төлөв байдалд гарсан өөрчлөлт, эсхүл ажиллагаагүй байдал, хэвийн бус ажиллагаа;

(c) Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий заавартаа заасан аэродромд нислэгийн дараах мэдээллийг илтгэх боломжоор нисэх багийн гишүүдийг хангах үүрэгтэй.

(d) Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь агаарын навигацийн байгууламжийн нөхцөл байдал болон үйл ажиллагаатай холбоотой энэ зүйлийн (c)-гийн дагуу нисэх багийн гишүүдийн илтгэсэн нислэгийн дараах мэдээллийг тухайн агаарын навигацийн байгууламжийн үйл ажиллагаа эрхлэгчид дамжуулах үүрэгтэй.

175.109. Гэрчилгээ эзэмшигч байгууллагын өөрчлөлт

(a) НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааврын нэмэлт өөрчлөлтийг тухайн байгууллагын болон үйлчилгээний хүчинтэй тодорхойлолт хэвээр хадгалагдаж байхаар хийдэг байхыг бататгах үүрэгтэй.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааврын нэмэлт өөрчлөлт нь энэ Дүрмийн холбогдох шаардлагад нийцэж байгаа болон Ерөнхий заавартаа заасан нэмэлт өөрчлөлт оруулах журмыг дагаж мөрдөж байгааг бататгах үүрэгтэй.

(c) Гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт оруулсан даруйд тухайн нэмэлт өөрчлөлтийн хувийг Даргын хэрэгцээнд зориулж цаг алдалгүй хүргүүлэх үүрэгтэй.

(d) Гэрчилгээ эзэмшигч дараах өөрчлөлтийг хийхээс өмнө Даргын зөвшөөрлийг урьдчилан авах шаардлагатай:

(1) Гүйцэтгэх захирал:

(2) нэр заагдсан удирдах ажилтнууд:

(3) гэрчилгээ эзэмшигчийн үзүүлдэг НМҮ:

(4) гэрчилгээний эрхийн хүрээнд хэвлэн нийтлэх нисэхийн мэдээллийн формат болон стандарт:

(5) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, хэрэв тухайн өөрчлөлт нь нөлөө бүхий өөрчлөлт бол:

(e) Энэ зүйлийн (d)-д заасан өөрчлөлтийг хийж байх үед, эсхүл хийсний дараа тухайн гэрчилгээ эзэмшигчийн ажиллах ёстой нөхцөлийг Дарга тогтоож болно.

(f) Энэ зүйлийн (e)-гийн дагуу Даргаас тогтоосон нөхцөлийг тухайн гэрчилгээ эзэмшигч дагаж мөрдөх үүрэгтэй.

(g) Энэ зүйлд заасан аливаа өөрчлөлт нь хэрэв тухайн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардсан бол гэрчилгээ эзэмшигч нь баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр гэрчилгээг Даргад нэн даруй хүргүүлнэ.

(h) Гэрчилгээ эзэмшигч нь Даргын нисэхийн аюулгүй байдалд шаардлагатай гэж үзсэн нэмэлт өөрчлөлтийг Ерөнхий заавартаа оруулна.

D Бүлэг - Монгол Улсын AIP

175.151. Монгол Улсын AIP-ын агуулга

(a) Монгол Улсын AIP нь дараах үйлчилгээтэй холбоотой хүчинтэй мэдээлэл, өгөгдөл болон нислэгийн зургийг багтаасан байх ёстой:

- (1) Монгол Улс НХУ хариуцдаг Монгол Улсын FIR-ийн агаарын навигацийн зохицуулалтын болон агаарын зайн шаардлага;
- (2) Монгол Улсаас болон Монгол Улс руу үйлдэх олон улсын агаарын навигацид дэмжлэг үзүүлдэг Монгол Улсын үйлчилгээ болон байгууламж;
- (3) Монгол Улсын FIR дэх агаарын навигацид дэмжлэг үзүүлдэг Монгол Улсын үйлчилгээ болон байгууламж;
- (4) ИНД-139-ийн дагуу олгосон аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэдэг аэродром.

(b) Монгол Улсын AIP нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа гүйцэтгэдэггүй аэродромд хамаарах хүчинтэй мэдээлэл, өгөгдөл болон нислэгийн зургийг багтааж болно, хэрэв:

- (1) тухайн аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь AIP-ын үйлчилгээ үзүүлдэг НМУ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигчийг уг аэродромд хамаарах шаардлагатай өгөгдөл болон мэдээллээр хангадаг бол;
- (2) тухайн аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь уг өгөгдөл болон мэдээллийн үнэн зөв, хүчинтэй байдлыг хариуцахаа хүлээн зөвшөөрсөн бол;

(c) Монгол Улсын AIP нь холбогдох хэсэгтэй дараах мэдээллийг багтаасан байх ёстой:

- (1) Монгол Улсын AIP-д орсон агаарын навигацийн байгууламж, үйлчилгээ болон журмыг хариуцсан, гэрчилгээжсэн байгууллагын талаар зөвлөгөө өгөх мэдэгдэл;
- (2) тухайн үйлчилгээ болон байгууламжийг ашиглахад шаардлагатай ерөнхий нөхцөл;
- (3) Конвенцийн Зүйл 38-ын дагуу Даргын гаргасан, ICAO-гийн стандарт, зөвлөмж, практик болон журамтай зөрүүтэй шаардлагын жагсаалт;
- (4) ICAO-гийн стандарт, зөвлөмж, практик болон журамд өөр аргаар хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн үйл ажиллагаа байгаа тохиолдолд Монгол Улсад мөрдөж байгаа чухал ач холбогдолтой стандарт, практик болон журмын хураангуй.

175.153. Монгол Улсын AIP-ын тодорхойлолт

(a) Монгол Улсын AIP-ыг бүрдүүлж байгаа мэдээлэл нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- (1) мэдээллийн зорилго, хамрах газарзүйн бүс болон тухайн мэдээлэл Монгол Улсын AIP-ын хэсэг болохыг заадаг байх;
- (2) ойлгомжтой дугаарласан, хуудасны дугаартай гарчгийг багтаасан бие даасан байх;
- (3) дараах этгээд хэвлэн нийтэлснийг заадаг байх:
 - (i) AIP-ын үйлчилгээ үзүүлдэг НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч;
 - (ii) Даргын олгосон гэрчилгээний эрхийн хүрээнд;
- (4) шаардлагагүй байдлаар тухайн мэдээллийг давтахгүй байх ба хэрэв давтах шаардлагатай бол, ижил байгууламж, үйлчилгээ, эсхүл журмын хувьд тухайн давтсан мэдээлэл нь хоорондоо зөрүүгүй байх ёстой;
- (5) хугацаатай байх, эсхүл хэрэв хэвлэл нь салдаг хуудастай бол, хуудас бүр нь хугацаатай байх ёстой. Хугацаа нь тухайн нисэхийн мэдээлэл хүчинтэй болох өдрийг тоогоор, сарыг үсгээр, жилийг тоогоор заасан байх ёстой.
- (6) AIP-ын Нэмэлт өөрчлөлтөөр, эсхүл тогтмол давтамжтай дахин гардаг байх;
- (7) бататгаагүй мэдээллийн үнэн зөв байх магадлалын түвшнийг тодорхой заасан байх.

(b) Салдаг хуудастай хэлбэрээр хэвлэн нийтэлсэн мэдээлэл нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- (1) хуудас бүрд, тухайн мэдээлэл хамаарах хуудас болон тухайн хуудас нь Монгол Улсын AIP-ын хэсэг болохыг заасан байх;
- (2) дараах шалгах хуудсыг багтаасан байх:
 - (i) тухайн мэдээлэлд багтсан хуудас, эсхүл нислэгийн зураг бүрийн хүчинтэй хугацаа болон хуудасны дугаар, эсхүл зургийн нэрийг заадаг;
 - (ii) AIP-ын Нэмэлт өөрчлөлттэй хамт гардаг;
 - (iii) аль мэдээлэлд хамаарахыг заадаг;
 - (iv) энэ зүйлийн (a)(5)-д заасан хуудасны дугаар болон хугацаатай хэвлэгддэг.

175.155. AIP-ын Нэмэлт өөрчлөлтийн тодорхойлолт

AIP-ын Нэмэлт өөрчлөлт нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) хэвлэн нийтэлсэн мэдээлэлд орсон бүх өөрчлөлт болон дахин хэвлэсэн хуудсанд орсон бүх шинэ мэдээлэл нь ялгах тэмдэг, эсхүл тэмдэглэгээгээр тодорхой танигддаг байх;
- (2) хуанлийн жилд үндэслэн, дараалсан серийн дугаартай байх.

175.157. AIP-ын Нэмэлтэд хавсралтын тодорхойлолт

- (a) AIP-ын Нэмэлт хавсралт нь хуанлийн жилд үндэслэн, дараалсан серийн дугаартай байна.
- (b) AIP-ын Нэмэлт хавсралтын хуудас нь түүний аль нэг агуулга хүчинтэй байгаа бол Монгол Улсын AIP-ын хүчинтэй хэсэг хэвээр байх ёстой.
- (c) Хүчинтэй AIP-ын Нэмэлт хавсралтын шалгах хуудсыг AIP-ын Нэмэлт хавсралттай хамт, эсхүл нэг сараас хэтрэхгүй давтамжтай гаргах ёстой. Шалгах хуудсыг тухайн Нэмэлт хавсралттай адил түгээнэ.

E Бүлэг - AIC

175.201. AIC-ын тодорхойлолт

- (a) AIC нь дараах шаардлагыг хангасан байна:
 - (1) хэвлэмэл хэлбэрээр түгээгддэг байх;
 - (2) хуанлийн жилд үндэслэн, дараалсан серийн дугаартай байх
- (b) Олон улсын агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчид хамаарах AIC-ыг AIP-тай адил түгээнэ.
- (c) AIC-ыг нэгээс илүү сериэр түгээх тохиолдолд, сери бүр нь эхний үсгээр тусдаа танигддаг байна.
- (d) Хүчинтэй AIC-ын шалгах хуудсыг жилд нэгээс доошгүй удаа гаргах ба AIC-тай адил түгээнэ.

F Бүлэг - NOTAM

175.251. NOTAM-ын тодорхойлолт

- (a) NOTAM нь NOTAM-ын нэгжээс олгосон А, эсхүл В серийн дугаартай байх ёстой. Серийн доторх серийн дугаар нь хуанлийн жилд үндэслэн, дараалсан байх ёстой.
- (b) А серийн NOTAM нь дараах нисэхийн мэдээллийг багтаасан байх ёстой:
- (1) Монгол Улсын FIR-д үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагааны чухал ач холбогдолтой;
 - (2) В серийн NOTAM-д хэвлэн нийтлээгүй.
- (c) В серийн NOTAM нь Монгол Улсын FIR-д үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа олон улсын үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагааны чухал ач холбогдолтой нисэхийн мэдээллийг багтаасан байх ёстой:
- (d) NOTAM-ыг товч, зөвхөн нэг сэдвийг хамарсан ба түүний утгыг өөр баримт бичигт ишлэл хийхгүйгээр тодорхой боловсруулсан байх ёстой.
- (e) Хэрэв NOTAM Монгол Улсын AIP-ын Нэмэлт өөрчлөлт, эсхүл AIP-ын Нэмэлт хавсралт шаардсан мэдээллийг багтаадаг бол, NOTAM нь Монгол Улсын AIP-ын текст, эсхүл AIP-ын Нэмэлт хавсралттай холбоотой харилцан хийсэн ишлэлийг багтаасан байх ёстой.
- (f) Хэрэв өмнөх NOTAM-ыг цуцалж, эсхүл сольж NOTAM гаргасан бол, өмнөх NOTAM-ын серийн дугаарыг заасан байх ёстой.
- (g) Хэрэв NOTAM-д алдаа илэрсэн бол, үндсэн NOTAM-ыг цуцалсан солих NOTAM-ыг гаргах ёстой.
- (h) NOTAM-ын текстэд багтсан байршил илтгэгч код нь ICAO-гийн баталсан кодтой тохирч байх ёстой.
- (i) Байршил илтгэгч кодыг хураангуйлсан хэлбэрээр ашиглаж болохгүй.
- (j) Хэрэв байршил илтгэгч кодыг тухайн байршилд олгоогүй бол, 175.61(b)(9)-ийн дагуу үсэглэн бичсэн тухайн газрын нэрийг NOTAM-ын текстэд оруулсан байх ёстой.
- (k) Энэ дүрмийн 175.105(6)-д шаардсан NOTAM-ын шалгах хуудас нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:
- (1) хамгийн сүүлчийн AIP-ын Нэмэлт өөрчлөлт, AIP-ын Нэмэлт хавсралт болон олон улсад түгээсэн AIC-д ишлэл татсан байх;
 - (2) ишлэл татсан серийн NOTAM-тай адил түгээгдэх ба шалгах хуудас гэж тодорхой тэмдэглэгдсэн байх.
- (l) В серийн NOTAM-ыг олон улсад түгээхэд тохиромжтой хэлбэрээр бэлтгэж боловсруулах ёстой.

175.253. NOTAM-ыг түгээх

- (a) NOTAM нь дараах шаардлагыг хангасан байна:
- (1) боломжтой бүх тохиолдолд, цахилгаан холбооны нэг мэдээгээр дамжуулагддаг байх;
 - (2) тухайн мэдээлэл үйл ажиллагаанд нь шууд ач холбогдолтой болон тухайн мэдээллийг өөр хэлбэрээр авах боломжгүй этгээдэд 7-гоос доошгүй хоногийн өмнө мэдээг түгээдэг байх.
- (b) А серийн NOTAM-ыг Монгол Улс дотор түгээнэ.
- (c) В серийн NOTAM-ыг Монгол Улс дотор болон 175.105(3)-ын дагуу байгуулсан гэрээлэгч олон улсын NOTAM-ын нэгжид түгээнэ.
- (d) Боломжтой бүх тохиолдолд NOTAM түгээхэд AFTN ашиглана.
- (e) Энэ дүрмийн 175.105(3)-ын дагуу байгуулсан гэрээний хүрээнд солилцсон NOTAM-ыг AFTN-ээс өөр хэрэгслээр илгээсэн тохиолдолд, тухайн NOTAM гаргасан цаг хугацааг харуулдаг 6 оронтой өдөр-цаг хугацааны тоо болон эх сурвалжийн таних тэмдгийг NOTAM-ын текстийн урд бичнэ.
- (f) Энэ дүрмийн 175.105(3)-ын дагуу бусад олон улсын NOTAM-ын нэгжтэй байгуулсан гэрээний хувьд, боломжтой бүх тохиолдолд, AFTN-ээр дамжуулдаг NOTAM-ын урьдчилан тогтоосон түгээлтийн системийг ашигладаг байх.

Г Бүлэг - Шилжилтийн зохицуулалт**175.301. НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн шилжилт**

- (a) Энэ зүйл нь дараах этгээдэд хамаарна:
- (1) НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч;
 - (2) НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч.
- (b) Энэ зүйлд хамаарах байгууллага нь энэ зүйлийн (e)(2)-ын дагуу тогтоосон хэрэгжүүлэлтийн хугацаанаас өмнө дараах заалтыг мөрдөх шаардлагагүй:
- (1) 175.51(a)(2)(ii), хэрэв байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтны оронд дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтантай бол;
 - (2) 171.67, хэрэв байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон мөрдөхийн оронд 171.303-ыг хангасан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн бол;
 - (3) 175.69(a)(1A)(i);
 - (4) 175.69(a)(3)(ii);
 - (5) 175.69(a)(5A).
- (c) НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч болон НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь гүйцэд бөглөсөн САА маягт болон хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг 2020 оны 2 сарын 1-нээс өмнө Даргад хүргүүлэх үүрэгтэй.

(d) Энэ зүйлийн (c)-д заасан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө нь дараах шаардлага хангах ёстой:

- (1) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн санал болгосон хугацааг багтаасан байх;
- (2) тухайн байгууллага 175.67-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг дүрслэн харуулсан байх.

(e) Хэрэв хүлээн зөвшөөрөхүйц бол, Дарга:

- (1) тухайн байгууллагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батална;
- (2) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн хугацааг тогтооно.

(f) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу хугацааг тогтоохдоо, Дарга дараах нөхцөлийг тооцох үүрэгтэй:

- (1) тухайн байгууллагын хүчин чадал;
- (2) тухайн байгууллагын төвөгшил;
- (3) байгууллагын үйл ажиллагаанд оршиж байгаа эрсдэл;
- (4) гэрчилгээг сунгах хугацаа;
- (5) тухайн байгууллага, эсхүл ИНЕГ, эсхүл хоёуланд нь хамаарах эх үүсвэр, эсхүл хуваарийн нөлөө;
- (6) хэрэгжүүлэлтийн хугацаа нь 2021 оны 2 сарын 1-нээс хойш байж болохгүй.

(g) Энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ сунгуулах хүсэлтэд хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг хавсаргахгүй байж болно.

(h) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-нд хүчингүй болно.

175.303. НМҮ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигчийн шилжилтийн дотоод чанар баталгаажуулалт

Энэ Дүрмээр шаардсан журам нь дүрмийн шаардлага хангасан ба тухайн байгууллага түүнийг хэрэгжүүлж байгааг бататгах зорилгоор 171.301(b)(1)(ii)-т шаардсан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх үүрэгтэй.

(a) Журамд дараах шаардлагыг заасан байх ёстой:

- (1) хүсэлт гаргагчийн хүрэхээр зорьж байгаа чанарын түвшин;
- (2) дотоод дүгнэлт хийх түвшин болон давтамж;
- (3) дотоод дүгнэлт хариуцсан ажилтан, эсхүл ажилтнууд;
- (4) дотоод дүгнэлтээр илэрсэн дутагдлыг хэрхэн бүртгэх болон Гүйцэтгэх захиралд илтгэх;
- (5) алдааны тайлан, зөрчил болон гомдол бүхий чанарын үзүүлэлтийг дотоод чанар баталгаажуулалтын журамд хэрхэн оруулах;
- (6) дотоод дүгнэлтэд дүн шинжилгээ болон үнэлгээ хийх удирдах ажилтны үүрэг хариуцлага;
- (7) дотоод дүгнэлтийн үед илэрсэн аливаа дутагдлыг залруулах аргачлал;

(8) дүгнэлтийн бүх асуудлын баримт бичгийг бүрдүүлэх шаардлага.

(b) Дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан нь хэвлэн нийтэлсэн нисэхийн мэдээллийн нийцэл, үнэн зөв, цаг хугацаа, формат болон түгээлтэд нөлөөлж байгаа асуудлаар Гүйцэтгэх захиралтай шууд харьцах эрхтэй байх.

(c) Энэ зүйл нь 2021 оны 2 сарын 1-нд хүчингүй болно.

--oOo--